

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017.12.07

Дагаж мөрдөх огноо

2019.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.05.01

Байгууллагын нэр:

Орхон аймаг
Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Захиргаа төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

ЦАЗН ажилгааны инженер бөгөөд сүлжээ,
аюулгүй ажиллагааны ажилтан

Албан тушаалын ангилаал, зэрэглэл

TY-7 / TYM-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймаг Баян-Өндөр сум
Баян-Цагаан баг тосгон

Хөдөлмөрийн нөхцөл:

хэвийн

Онцгой нөхцөл:

Ажлын ачаалал даах чадвартай,
шаардлагатай үед илүү цагаар

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн зэвсэг техникийн бэлэн байдал, аюулгүй ажиллагааг ханган хяналт тавин ажиллаж, ХАБЭА-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, заавар зөвлөмж өгөх, байгууллагын ажлын орчин, ажлын байрны аюулгүй ажиллагааг хангах, байгууллагын цахим сүлжээ, хяналтын камерын тасралтгүй, найдвартай үйл ажиллгагааг хангах,

1. Удирдлагын дэмжлэгтэйгээр ХАБЭА-ын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээ, тайланг хүргүүлж, ажилтнуудын эрүүл мэнд, ажлын байрны аюулгүй ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх,
2. Үүлэнд зориудаар нөлөөлөх ажиллагаа пуужин харвалтыг удирдах,
3. Өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл технологийн чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гадаад дотоод цахим сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах,

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэл-ийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилт ын хүрээнд	<p>1. ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журмыг судлан онолын мэдлэгээ байнга дээшлүүлж байх,</p> <p>2. Ажлын төлөвлөгөөг гарган баталгаажуулж, тайланг хагас бүтэн жилээр гаргах,</p> <p>3. Аюулыг олж илрүүлэх, түүнд хяналт тогтоож арилгах арга чадварыг нийт ажилтнуудад эзэмшүүлэх арга хэмжээ авах, аюулыг мэдээлэх түүний мөрөөр уг аюул эрсдлийг үнэлэх, арилгах тогтолцоо бий болгох; /галын болон байгальн аюул/</p> <p>4. Аливаа шинэ ажлыг хийхээр төлөвлөгдсөн даруй эрсдлийн үнэлгээ, ажлын аюулын шинжилгээ хийлгэх, хийх ажлыг хариуцан хангунд газар дээр нь засч залруулах арга хэмжээг бүрэн авагдсаны дараа тухайн ажлыг эхлүүлэх;</p> <p>5. Ажилтнууд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсэн эсэхэд хяналт тавих, шаардлагатай судалгаа, дүгнэлт, зөвлөмжийг өгөх;</p> <p>6. Хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтнуудын ажлын байранд хяналт тавих ХАБЭА-н дотоод хяналт шалгалтыг хийх, бүртгэл хөтлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах,</p>	Аюул эрсдэлгүй ажилласан байна.	Г,Х
2 дугаар зорилт ын хүрээнд	<p>1. Пуужин, харвах төхөөрөмжийн засвар, үзлэг үйлчилгээг тогтмол хийж, хадгалалт тээвэрлэлтийн журмыг чанд сахин, байнгын бэлэн байдлыг хангах,</p> <p>2. Хээр байрлах газар орныг сонгох, галт хэрэгсэл, пуужинг харвалтанд бэлтгэх, шалгах, харвалтыг удирдах, ажлын явцыг хянах,</p> <p>3. Үүлэнд үйлчлэх, регент цацах солбицолыг тодорхойлох, ЦАЗН-үйл ажиллагааны үр дүнг тооцох,</p> <p>4. Үйл ажиллагааны талаарх акт, тайлан, мэдээ мэдээллийг цаг тухайд нь хийж, дээд газарт тайлгагнах,</p> <p>5. Зэвсэг, галт хэрэгсэл, пуужинтай харьцах сургалтад хамрагдан ажиллах эрхийн гэрчилгээ авах</p>	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа үр дүнтэй, хэвийн явагдсан байна.	Г,Х
3 дугаар зорилт ын хүрээнд	<p>1. Мэдээлэл технологийн чиглэлээр шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлж, албан хаагчдад танилцуулж, зааварчилгаа өгөх,</p> <p>3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах,</p> <p>4. Байгууллагын компьютеруудын бэлэн байдлыг хангаж, интернет орчинд сүлжээг вирусээс хамгаалах, засвар үйлчилгээг тогтмол хийх,</p> <p>5. Гадаад, дотоод мэдээ солилцоо, мэдээлэл үйлчилгээний ажлын явцад хяналт тавьж, гарсан saat ал, зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авч байх,</p> <p>6. Газардуулга, аянга зайлцуулагч, зайд хураагуурууд (UPS тэжээлийн блок, компьютер) цахилгаан тэжээлийн хэвийн байдлыг тогтмол хянаж, шалгаж байх,</p>	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, сүлжээний аюулгүй байдал, нууцлалын шаардлага хангагдаж, үйл ажиллагаа тасралтгүй явуулсан байна.	Г,Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА


Боловсрол	Баклавар, түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	ЦУОШГ-ын үүлэнд зориудаар нөлөөлөх экспедицэд ажиллах мэргэжлийн үнэмлэхтэй байх, ХАБЭА-ын сургалтад хамрагдсан зохих мэдлэгтэй байх	
Мэргэшил	Цаг агаарт зориудаар нөлөөлөх чиглэлээр мэргэшсэн, компьютер, програмчлал, сүлжээний чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага	Онолын ба ажлын дадлагатай байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> ❖ Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох, тайлагнах ❖ Техник сэтгэлгээ, бие дааж ажиллах ❖ Мэдээллийн сангийн талаар, түүний бүтэц загварчлалын талаар үндсэн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> ❖ Хийсэн ажлынхаа үр дагаварыг хариуцах ❖ Оновчтой шийдвэр гаргадаг байх
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> ❖ Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байх ❖ Бусадтай харилцан итгэл төрүүлхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох ❖ Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах
	Бусад	<ul style="list-style-type: none"> ❖ Баримт бичиг боловсруулах чадвартай байх ❖ Компьютерийн өргөн хэрэглээний программыг ашиглаж чадддаг ❖ Бие даан мэргэшлээ дээшлүүлэх чадамжтай байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Төвийн дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1.Бух инженер, техникчид	Бусад харилцах субъект Байгууллагын дотор 1.3Т-ийн хэлтсийн дарга 2.ЦУТМҮ-ийн хэлтсийн дарга Байгууллагын гадна 1.ЦУОШГ-ын улсын сүлжээ уур амьсгал үйлчилгээний хэлтэс
--	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: Албан тушаал: Хүний нөөцийн ажилтан  Б.Болортцэг	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: Байгууллагын нэр: Ус цаг уур орчны шинжилгээний төв Шийдвэрийн огноо: 2023.05.01 Дугаар: 01
(Гарын үсэг) (эцэг/эх-/ийн нэр еөрийн нэр) 20... оны ... дугаар сарын 01 -ны өдөр	

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо: 2023.05.01

Дугаар: 01
(тамга/тэмдэг)



20... оны ... дугаар сарын 01 -ны өдөр

Сүрэнгийн Отгонбаатар
(Эцэг/эх-/ийн нэр, еөрийн нэр)